



# ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 3 сарын 23 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

## Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, 96 дугаар зүйлийн 96.5 дах заалт болон Тандэм Инвэст ББСБ ХК-ийн 2022 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дүгнэлтийг Хавсралт №1-р баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.ЧИНЗОРИГ



Тандэм Инвэст ББСБ ХК-ийн ХЭ-ийн ээлжит  
2022 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн  
ХК 2 тоот тогтоолын Хавсралт №1

## ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ АУДИТЫН ХОРООНЫ ТАЙЛАНГИЙН ДҮГНЭЛТ

Тайлант хугацаанд Тандэм Инвэст ББСБ ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх Аудитын Хорооноос компанийн Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлага нь хууль тогтоомж, компанийн дүрэм, хувь нийлүүлэгчдийн хурлаас олгогдсон эрх хэмжээний хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа эсэх, мөн компанийн санхүүгийн үйл ажиллагаанд дэд хорооны эрх үүргийн хүрээнд хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгон хяналт тавьж ажиллалаа.

### Компанийн санхүүгийн үйл ажиллагааны талаар:

Тандэм Инвэст ББСБ ХК-ийн жилийн эцсийн санхүүгийн тайланд 2020 оноос эхлэн СЗХ-нд бүртгэлтэй Шинэ Их Тэрбум Аудит ХХК хөндлөнгийн аудит хийн ажиллаж байна.

Компанийн хувьд 2021 онд 1'138.2 сая төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан нь өмнөх онтой харьцуулахад абсолют утгаараа 495.1 сая төгрөгөөр илүү буюу 77 хувиар өссөн дүнтэй гарчээ. Ковид-19 цар тахлаас улбаатайгаар 2020 онд цэвэр ашиг 26.6 хувиар буурч байсан боловч 2021 оноос хязгаарлалтын сулруулж эдийн засгийн үйл ажиллагааг тодорхой түвшинд чөлөөлсөн нь иргэд, аж ахуйн нэгжийн хувьд харьцангуй чөлөөтэй үйл ажиллагаа явуулах боломж бүрдсэнтэй холбоотойгоор эдийн засгийн үйл ажиллагаа сэргэж компанийн хувьд 2021 онд хуримтлагдсан ашиг өмнөх онтой харьцуулахад 2 дахин өссөн.

Орлогын дэлгэрэнгүй тайлангаас авч үзвэл компанийн борлуулалтын орлогод борлуулалт маркетингийн зардал 35.2 хувийг эзэлж байна.

Тайлант хугацаанд гарсан үйл ажиллагааны зардлыг ангилж үзвэл:

Цалин -	203.0 сая төгрөг
Аудит, мэргэжлийн үйлчилгээ-	89.5 сая төгрөг
Түрээс-	17.6 сая төгрөг
Нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгал-	19.9 сая төгрөг
Маркетинг сурталчилгаа -	4.4 сая төгрөг
Зохицуулалтын хураамж-	12.7 сая төгрөг
Зээл барагдуулахтай холбоотой зардал-	0.8 сая төгрөг

### **Авлага, өглөгийн талаар:**

Тайлант хугацаанд бусдаас авсан урт хугацааны өр төлбөргүй богино хугацааны өр төлбөр 1'117 сая төгрөг. Татварын өглөг 3.5 сая төгрөг байна.

Эздийн өмч ба өр төлбөрийн дүнд богино хугацаат өр төлбөр 16.1 хувийг эзэлж байгаа бол урт хугацааны өр төлбөргүй байна. Эздийн өмч ба өр төлбөрийн нийт дүнд эздийн өмчийн эзлэх дүн 83.9 хувьтай байна.

### **Эргэлтийн болон Үндсэн хөрөнгийн талаар:**

2021 оны эцсийн байдлаар үндсэн хөрөнгийн хэмжээ 43.7 сая төгрөг болсон бөгөөд энэ нь өмнөх онтой харьцуулахад 95 хувиар өссөн дүн юм.

Компанийн зах зээлд зээлийн үйл ажиллагаа явуулж байгаатай нягт холбоотойгоор нийт хөрөнгөд эзлэх эргэлтийн хөрөнгийн хувь 99.3 байна. Өөрөөр хэлбэл компанийн хувьд үндсэн хөрөнгө нь нийт хөрөнгөд маш бага хувь эзэлдэг байна.

### **Нягтлан бодох бүртгэл ба тайлагнал:**

Компанийн 2021 оны санхүүгийн болон удирдлагын үйл ажиллагааг санхүүгийн тайлан, анхан шатны баримт, холбогдох бусад баримт, тайлантай тулган хянахад Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт, Нягтлан Бодох Бүртгэлийн тухай хууль мөн компанийн тухай хууль болон холбогдох журам зааврын дагуу бүртгэлээ хөтөлж, санхүүгийн тайлангаа хуульд заасан хугацаанд тайлагнаж харьяа санхүүгийн болон татварын байгууллагад тушаасан байна.

Тайлант хугацаанд хувьцаа эзэмшигчид болон ТУЗ-өөс өмч хөрөнгийн ашиглалт зарцуулалт, компанийн удирдлага, албан тушаалтнуудын явуулж байгаа бодлого, үйл ажиллагааны талаар санал гомдол, хүсэлт ирээгүй болно.

Хараат бус аудиторын тайлангаас гаргасан дүгнэлтээр ББСБ-ын санхүүгийн тайлангууд нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт ("СТОУС")-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн гэж дүгнэгдсэн болно.

**ТУЗ-ийн дэргэдэх Аудитын Хороо**

# ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 3 сарын 23 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

## Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлж, сонгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дэх заалт, 77 дугаар зүйлийн 77.4 дэх хэсэг, Тандэм Инвэст ББСБ ХК-ийн 2022 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Тандэм Инвэст ББСБ ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийг дараах бүрэлдэхүүнээр сонгосугай.

### 1.1 Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүнээр:

Ч.Чинзориг  
Ч.Бадмаараг  
Л.Очирмаа  
Ц.Билэг-Өрнөх  
Ч.Тэмүдэр  
Б.Золжаргал

### 1.2 Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүнээр:

А.Даваазориг  
Ч.Лодойравсал  
Б.Энх-Амгалан

2. Компанийн үр ашигтай ажиллагааг удирдан зохион байгуулж, холбогдох хууль, дүрэм журмын дагуу ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.ЧИНЗОРИГ

# ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 3 сарын 23 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

## Нэмэлт хувьцаа гаргах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2.2, 38 дугаар зүйлийн 38.8, 42 дугаар зүйлийн 42.1, 62 дугаар зүйлийн 62.1.3 дэх заалт, 87 дугаар зүйлийн 87.1.1 заалт, Тандэм Инвэст ББСБ ХК-ийн 2022 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн эргэлтийн хөрөнгийг нэмэгдүүлэх, зах зээлд эзлэх байр суурийг бэхжүүлэх үүднээс Монголын Хөрөнгийн Биржийн арилжааны сүүлийн 6 сарын жигнэсэн дундаж ханшийг үндэслэн нэг бүр нь 19.50 төгрөгийн үнэ бүхий 377,029,177 ширхэг, энгийн хувьцааг, хаалттай хүрээнд нэмж гаргасугай.
2. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор компанийн нийт зарласан хувьцаа болох 3,003,866,050 ширхэг хувьцаанаас 377,029,177 ширхэг энгийн хувьцааг хаалттай хүрээнд гаргахыг баталсугай.
3. Компанийн тухай хуулийн 38.8-д заасны дагуу тэргүүн ээлжид худалдан авах эрхийг хэрэгжүүлэхгүй байхаар тогтоосугай.
4. Хувьцаа нэмж гаргаж байгаатай холбогдуулан компанийн хөрөнгө нэмэгдэж, гаргасан хувьцааны тоонд өөрчлөлт орох тул тус өөрчлөлтийг компанийн дүрэмд тусган холбогдох газруудад бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал (Б.Золжаргал)-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.ЧИНЗОРИГ

1. Хаалттай хүрээнд нэмэлт энгийн хувьцаа гаргах тооцоолол

Нэмж гаргах хувьцаа	377,029,177
Нэгж хувьцааны үнэ	19.50 төгрөг
Нэмж гаргаж буй хувь	25%
Татан төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ	7,352,068,951.50

2. Хөрөнгө оруулалтын зарцуулалт

Эргэлтийн хөрөнгө	100%
-------------------	------

# ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 3 сарын 23 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

## Компанийн дүрмийн сан нэмэгдүүлэх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйл 31.2.2 дэх заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн 10 тоот тогтоолын 2.2.5 дах заалт, Тандэм Инвэст ББСБ ХК-ийн 2022 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компани хаалттай хүрээнд нэмэлт хувьцаа гаргаж байгаатай холбогдуулан компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 3,468,668,428.40 /Гурван тэрбум дөрвөн зуун жаран найман сая зургаан зуун жаран найман мянга дөрвөн зуун хорин найман төгрөг дөчин мөнгө/ төгрөг болгон нэмэгдүүлсүгэй.
2. Компанийн дүрмийн сангийн тооцооллыг Хавсралт №1-ээр баталсугай.
3. Энэхүү тогтоол гарсантай холбоотойгоор хийгдэх өөрчлөлтийг холбогдох эрх бүхий байгууллагад албан ёсоор бүртгүүлэх ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал /Б.Золжаргал/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.ЧИНЗОРИГ



Тандэм Инвэст ББСБ ХК-ийн ХЭ-ийн ээлжит  
2022 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн  
05 тоот тогтоолын Хавсралт №1

ДҮРМИЙН САНГИЙН ТООЦООЛОЛ

Тайлбар	Одоо	Нэмэлт хувьцаа	Нийт
Дүрмийн сан	2,601,501,321.30	867,167,107,10	3,468,668,428.40
Хувьцааны тоо	1,131,087,531	377,029,177	1,508,116,708
Хувьцааны нэрлэсэн үнэ	2 төгрөг 30 мөнгө	2 төгрөг 30 мөнгө	2 төгрөг 30 мөнгө

# ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 3 сарын 23 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

## Үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл нэмж авах тухай

Монгол Улсын банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7 дугаар зүйл, Тандэм Инвэст ББСБ ХК-ийн 2022 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх бодлогын хүрээнд банк бус санхүүгийн дараах үйлчилгээний тусгай зөвшөөрлүүдийг шат дараатайгаар нэмж авсугай. Үүнд:
  - 1.1 Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх;
  - 1.2 Факторинг;
  - 1.3 Төлбөрийн баталгаа гаргах;
  - 1.4 Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ;
2. Энэхүү тогтоол гарсантай холбоотойгоор хийгдэх өөрчлөлтийг холбогдох эрх бүхий байгууллагад албан ёсоор бүртгүүлэх ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал /Б.Золжаргал/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.ЧИНЗОРИГ

# ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

## Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны төсөв батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13, 62.1.15 дах заалт Тандэм Инвэст ББСБ ХК-ийн 2022 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Тандэм Инвэст ББСБ ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны зардлын төсвийг Хавсралт №1-р баталсугай.
2. Батлагдсан төсвийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Золжаргал)-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.ЧИНЗОРИГ



Тандэм Инвэст ББСБ ХК-ийн ХЭ-ийн ээлжит  
2022 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн  
07 тоот тогтоолын Хавсралт №1

Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлын төсөв

№	Зардлын төрөл	Тоо	Нэгжийн зардал	Нийт зардал
1	Цалин /дарга/	1	580,000	6,960,000
2	Цалин /гишүүд/	8	420,000	40,320,000
3	Цалин/ нарийн бичгийн дарга/	1	420,000	5,040,000
4	ТУЗ ээлжит хурлын зардал	4	350,000	1,400,000
5	ТУЗ ээлжит бус хурлын зардал	6	350,000	2,100,000
6	ТУЗ-н бичиг хэрэг			500,000
7	ТУЗ-ын томилолт			20,000,000
Нийт дүн				76,320,000

# ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 3 сарын 23 өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

## Компанийн дүрмийн өөрчлөлтийг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалт, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, Тандэм Инвэст ХК-ийн 2022 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг энэхүү тогтоолын Хавсралт №1-ээр баталсугай.
2. Дүрмийн шинэчилсэн найруулгыг холбогдох хууль тогтоомжид заасан хугацаанд Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэх, дүрмийн хувийг Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид хүргүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Золжаргал)-д үүрэг болгосугай.
3. Дүрмийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл, Гүйцэтгэх удирдлагад тус тус үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.ЧИНЗОРИГ



Тандэм Инвэст ББСБ ХК-ийн ХЭ-ийн ээлжит  
2022 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн  
08 тоот тогтоолын Хавсралт №1

ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ийн дүрэмд орох өөрчлөлтүүд:

Харьцуулалтууд		
Хуучин	Шинэчилсэн	Тэмдэглэл
	3.1.5 Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх; 3.1.6 Факторинг; 3.1.7 Төлбөрийн баталгаа гаргах; 3.1.8 Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ;	Нэмсэн
6.1.1 Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь 2,601,501,321.30 /Хоёр тэрбум зургаан зуун нэг сая таван зуун нэг мянга гурван зуун хорин нэгэн төгрөг гучин мөнгө/ төгрөг байна.	6.1.1 Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь 3,468,668,428.40 /Гурван тэрбум дөрвөн зуун жаран найман сая зургаан зуун жаран найман мянга дөрвөн зуун хорин найман төгрөг дөчин мөнгө/ төгрөг байна.	Шинэчилсэн
6.2.2 Компани нэг бүр нь 2.30 /хоёр төгрөг гучин мөнгө/ төгрөгийн нэрлэсэн үнэтэй 1,131,087,531 /Нэг тэрбум нэг зуун гучин нэгэн сая наян долоон мянга таван зуун гучин нэгэн/ ширхэг гаргасан энгийн хувьцаатай байна.	6.2.2 Компани нэг бүр нь 2.30 /хоёр төгрөг гучин мөнгө/ төгрөгийн нэрлэсэн үнэтэй 1,508,116,708 /Нэг тэрбум таван зуун найман сая нэг зуун арван зургаан мянга долоон зуун найман/ ширхэг гаргасан энгийн хувьцаатай байна.	Шинэчилсэн